

МОНГОЛ УЛСЫН «ГУРАВДАГЧ ХӨРШ»-ИЙН БОДЛОГО: ОНОЛЫН БАРИМТЛАЛ, ТҮҮХ, ОРЧИН ҮЕИЙН ЗАНГИЛАА АСУУДАЛД

Д.Уламбаяр⁵

I. Удиртгал

1990-ээд оны эхнээс Монгол Улсын гадаад бодлогод «гуравдагч хөрш», «гуравдагч хөрш»-ийн бодлогын үзэл санаа буй болж, эдүгээ тухайлсан төрийн бодлого хийгээд онол-практикийн түвшний судалгааны шинэ чиглэл болов. Эл судалгаа нь 1960-аад оноос эхэлсэн «БНМАУ-ын капиталист биш хөгжлийн замын түүхэн туршлага» сэдэвт судалгааны ажлаас хойшхи нийгмийн ухааны салбарын Монгол Улсын гадаад бодлого, олон улсын харилцааны чиглэлийн хамгийн том судалгааны ажлын шинэ чиглэл хэмээн үзэж байна. Тиймээс дурдсан чиглэлд судлаачид анхаарлаа хандуулж буй нь бүрнээ зүй ёсны хэрэг юм. Зарим судлаачид «гуравдагч хөрш» гэж байхгүй, хөрш гэдэг нь хаяа дэрлэсэн байх ёстой, харин «гуравдагч түнш» гэж байж болох юм хэмээн мэтгэлцдэг. Уг нь сайхь бодлогын логик нь «гуравдагч хөрш»-ийн тухайд бодлого явуулж, харин тэрхүү бодлогын хүрээнд түншлэлийн харилцааг хөгжүүлэх асуудал л байгаа юм. Зарчмын цоо шинэ үүрэгтэй болсон мэдээлэл, харилцаа, холбооны технологийн үсрэнгүй хөгжилтэй уялдан орон зай, цаг хугацаа, хөршийн тухай уламжлалт ойлголт улам бүр харилцан хамааралтай даяаршсан эдүгээ үед үндсээрээ шинэчлэгдсэн гэдгийг энд тэмдэглэх ёстой.

Аливаа улс орон өөрийн үндэсний язгуур эрх ашиг, аюулгүй байдлаа улс төр-дипломатын болон эдийн засгийн аргаар хангахын тулд тусгайлан томъёолсон гадаад бодлого, дипломат ажиллагааг эрхлэн явуулж, тэр нь олон улсын дэмжлэг хүлээж байсан нь цөөнгүй. Үүний тод жишээ нь

⁵ Д.Уламбаяр, ХИС-ийн Олон улс судлалын сургалт, судалгааны төвийн захирал, доктор, профессор

1988 онд тунхагласан БНСУ-ын Ерөнхийлөгч Но Тэ-үүгийн (Roh Tae-woo) «Northern diplomacy» юм. Сайхь бодлогын мөн чанар нь Хойд Солонгосын хамгийн ойрын холбоотон коммунист орнуудтай дипломат харилцаа тогтоож, олон улсын харилцаанд өөрийн улс төрийн байр сууриа бэхжүүлэх, улам бүр өсөн нэмэгдэж буй эдийн засагт хэрэгцээтэй түүхий эд, борлуулалтын болон санхүү, худалдаа-хөрөнгө оруулалтын шинэ зах зээл нээх, НҮБ-д БНАСАУ-тай нэгэн зэрэг гишүүнээр элсэх (гол нь НҮБ-ын АЗ-ын Байнгын гишүүн ЗХУ, БНХАУ-ын байр сууриас шалтгаалан дангаараа элсэх боломжгүй байв), Хойд Солонгосыг нээлттэй болгох, үндэсний нэгдлийг хэрэгжүүлэхэд оршиж байв. АНУ-ын Ерөнхийлөгч том Ж.Буш, Зөвлөлтийн удирдагч М.С.Горбачёв нар сайхь бодлогыг бүрэн дэмжсэн юм. "Умардын бодлого"-ыг социалист орнууд, түүний дотор Монгол Улсын тухайн үеийн удирдагчид нааштайгаар хүлээн авч, дипломат харилцаа тогтоох санаачилгыг анхлан гаргаж байв. Монгол Улсын «гуравдагч хөрш» -ийн бодлого БНСУ-ын "умардын бодлого"-той олон талаараа адил төстэй. Дээрх бодлогоос хойш 10 жилийн дараа 1998 онд Ерөнхийлөгч Ким Дэ-жүнь (Kim Dae-jung) «Sunshine policy» буюу "Нарны илч"-ийн бодлогыг тунхагласан нь "умардын бодлого"-ын үргэлжлэл байсан гэж үздэг. Энэхүү бодлогын үр дүнд 2000 онд хоёр Солонгосын удирдагчдын дээд уулзалт зохиогдож, Ким Дэ-жүнь энхтайвны салбарт Нобелийн шагнал хүртсэн билээ.

БНМАУ, ХБНГУ-тай дипломат харилцаа тогтоосны эх сурвалж нь аанай л Холбооны канцлер, социал-демократ Вилли Брандтын явуулсан «Ostpolitik» буюу "Дорнодын бодлого"-той юуны өмнө холбоотой байв. Герман нь Солонгосын адил дэлхийн II дайны дараа хоёр хуваагдсан билээ. «Ostpolitik»-т ЗХУ-ын нөлөө туссан хэдий ч Вилли Брандт тууштай прагматик бодлого явуулж, ХБНГУ "Бүх Германыг төлөөлөх цорын ганц улс" гэсэн зарчмаасаа татгалзаж, 1970 онд ХБНГУ ба ЗХУ, ХБНГУ ба БНПАУ-ын гэрээнд гарын үсэг зурж, уг гэрээнд Европ дахь хил хязгаар, түүний дотор Одер-Нейсийн хил, ХБНГУ, БНАГУ-ын хоорондын хилийг халдашгүй гэдгийг хүлээн зөвшөөрч, гэрээ 1972 оны 6 дугаар сарын 3-наас хүчин төгөлдөр болжээ. ХБНГУ нь Чехословак, Болгар, Унгартай харилцаагаа хэвийн болгож, дипломат харилцаа тогтоон,

Баруун Берлиний асуудлаар дөрвөн гүрний хэлэлцээр байгуулж, улмаар 1973 онд хоёр Герман НҮБ-д адил тэгш эрхт хууль ёсныхоо суудлыг эзэлсэн нь «Ostpolitik»-ийн гол үр дүн байв. Улмаар Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны Хельсинкийн Төгсгөлийн баримт бичигт Европын хил хязгаарын халдашгүйг нотлон Европын 33 орон (Албаниас бусад) болон АНУ, Канад гарын үсэг зурсан юм. «Ostpolitik» ХБНГУ-ын үндэсний язгуур эрх ашигт бүрнээ нийцсэн юм. "Дорнын бодлого"-ыг санаачлан хэрэгжүүлж эхлүүлсэнийхээ төлөө Вилли Брандт 1971 онд энхтайвны салбарт Нобелын шагнал хүртсэн юм.

Европ тивд буй болсон намжмал байдлын нааштай уур амьсгал БНМАУ, ХБНГУ-ын хооронд 1974 оны 1 дүгээр сарын 31-нд дипломат харилцаа тогтоох үндсэн нөхцлийг бүрдүүлжээ. Дипломат харилцаа тогтоох санал, санаачлага ХБНГУ-ын талаас гарсан гэдгийг тэмдэглэх хэрэгтэй бөгөөд сайхь үйл явц 1973 оныг 5 дугаар сараас хоёр талын Лондон хотноо эхэлсэн зургаан удаагийн яриа хэлэлцээрийн үр дүн байв. "Дорнын бодлого", "умардын бодлого", "гуравдагч хөрш"-ийн бодлогын нийтлэг үндэслэл нь хүчний тэнцвэр юм.

Ер нь аливаа улс орны хувьд хөршүүд гэдэг нь ямагт чухал үүрэгтэй байдаг бөгөөд тухайн орны бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлоход үлэмж чухал нөлөө үзүүлдэг.

Дипломатын түүхэнд «гуравдагч хөрш», түүнд хандсан бодлогын асуудал ямагт байсаар ирсэн бөгөөд эдүгээ ч ач холбогдлоо алдаагүй гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Аль нэгэн бага буурай улс хоёр их хүчний шахалт, заналхийлэл, бүр түрэмгийлэлд өртөж тусгаар тогтнолоо алдах, газар нутгаа булаалгах асуудалтай тулгарахдаа гуравдагч хүчний ивээл тусламжийг эрэн хайж байсан баримт олон улсын харилцаа, дипломатын түүхэнд цөөнгүй байсан юм.

«Гуравдагч хөрш» хийгээд «гуравдагч хөрш»-ийн бодлого хэмээх ухагдахуун нь Монгол зэрэг хоёр их гүрний дунд орших, цэрэг-эдийн засгийн чадамж сул, хүн ам бага, улсад юуны түрүүнд хамаарах, үндэсний аюулгүй байдлаас үүдэн гарсан бодлогын асуудалтай холбоотой. Гэхдээ олон улсын харилцаа, дипломатын түүхэнд «гуравдагч хүчин»-ийг

хайсан баримтуудаас харахад зөвхөн хоёр улстай хиллэдгээс шалтгаалан гардаг ойлголт, бодлогын асуудал гэж үзэж хараахан болохгүй юм.

XIX зууны сүүлчээр тухайн үедээ Сиам гэж нэрлэгдэж байсан өнөөгийн Тайландын Вант улсад Бирмийн талаас Их Британи нөлөөгөө ихэсгэж, Энэтхэг-Хятадын хойгоос Франц санаархаж тус улсын бие даасан байдалд аюул занал учрахад Вангийн ордныхон цэрэг-эдийн засгийн хүчин чадал бүхий, тухайн үедээ Зүүн Өмнөд Азид язгуур ашиг сонирхолгүй байсан Хаант Орост хандаж дипломат дэмжлэг эрэн хайсан баримт байдаг.

1962 оны Карибын тэнгисийн пуужингийн хямралын үед Кубад хийгээд Вьетнамын дайны үед тухайн улсад нэг ёсондоо ЗХУ «гуравдагч хөрш» нь байсан гэж хэлж болохоор байдаг. Үүний уг сурвалж нь АНУ-тай сөргөлдөж байсан хүйтэн дайны үед Америкийн бөөрөнд болон Энэтхэг, Хятадын хойгт ЗХУ-ын асар том ашиг сонирхол байсанд оршино. Ер нь АНУ тэргүүтэй Өрнөдийнхэнтэй сөргөлдөж байсан хэнтэй боловч дотносох нь ЗХУ-ын гадаад бодлогын чухал чиглэл болж байв. Эндээс харахад бага жижиг улс «гуравдагч хөрш» хэмээн найдаж буй улсдаа хандахад тухайн «гуравдагч хөрш» нь тус бүс нутагт өөрийн цэрэг-улс төр, эдийн засгийн томоохон ашиг сонирхолтой байх явдал юм. АНУ-ын хувьд ардчилал, зах зээлийн эдийн засаг, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн хүндэтгэж буй улс орнуудтай түншлэл, стратегийн харилцааг хөгжүүлэх нь гадаад бодлогынх нь тэргүүлэх зарчим байдаг. АНУ тэдгээр орнуудыг улс төр-дипломатын аргаар дэмжиж, эдийн засгийн тусламж үзүүлдэг.

II. «Гуравдагч хөрш» хэмээх нэр томъёоны гарал үүсэл

1990 онд АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жеймс Бейкер Монгол Улсад албан ёсны айлчлал хийх үеэрээ АНУ Монгол Улсын хувьд «гуравдагч» хөрш байж болох үзэл санааг анхлан гаргасан гэж үздэг. 1990 оны 7 дугаар сарын 26-нд Ж.Бейкер ГЯЯ-ны сайд Ц.Гомбосүрэнгтэй өргөтгөсөн хэлэлцээ хийх үеэрээ: ***«БНМАУ хоёр хөрштэй. АНУ тэдний аль нэгтэй харилцахдаа танай харилцаанд сэв суулгахыг боддоггүй. Танай улс АНУ-ыг оролцуулж гурван том улстай***

сайн хөршийн харилцаатай байж болох юм».¹ гэж тэмдэглэн хэлжээ. Энэ үе бол Монгол Улсад анхны ардчилсан сонгууль явагдаж дуусаад удаагүй байв. Ж.Бейкер Ерөнхийлөгч бага Ж.Бушийн эцэг том Бушийг Ерөнхийлөгч байх үед 1989-92 онд АНУ-ын гадаад харилцааны Төрийн нарийн бичгийн дарга, 1992-93 онд Цагаан Ордны Тамгын газрын даргын албыг хашиж байсан юм.

1998 оны 5 дугаар сард АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Мадлен Олбрайт Монголд айлчлал хийх үеэрээ УИХ-д Танхимд үг хэлэхдээ: «АНУ алс хол оршдог ч Монгол Улс нь ардчилалын үнэт зүйлсийг дээдэлж, нээлттэй эдийн засгийг тууштай баримталдгийнхаа хувьд хөрш айлдаа ирсэн мэт ойр дотно сэтгэгдэл төрж байна»² гэсэн байна. 2004 оны 7 дугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгч АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Бушийн урилгаар тус улсад албан ёсны айлчлал хийж, төгсгөлд нь гаргасан Хамтарсан Мэдэгдэлд: «...ардчилсан хоёр орны хооронд хамтын үнэт зүйл болон стратегийн нийтлэг эрх ашигт тулгуурласан хамтын ажиллагаа, иж бүрэн түншлэлийн шинэ эрин үеийг зарлан тунхаглав».³ АНУ-ын Ерөнхийлөгч Жорж Буш Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын урилгаар тус улсад 2005 оны 11 дүгээр сарын 21-нд албан ёсны айлчлал хийх үеэрээ Төрийн ордны их Танхимд үг хэлэхдээ: «Албаа хашиж байхдаа Монголд айлчилсан Америкийн анхны Ерөнхийлөгч болж байгаадаа их баяртай байна. Америк орон танай "гуравдагч хөрш" гэдгээрээ бахархдаг билээ»⁴ гэж онцлон тэмдэглэсэн билээ. Айлчлалын үр дүнд гаргасан Хамтарсан Мэдэгдэлд: «...Ардчилсан хоёр орны хамтын үнэт зүйлс, стратегийн нийтлэг эрх ашигт тулгуурласан иж бүрэн түншлэлийн удирдах зарчмыг тодорхойлж, цар хүрээг нь өргөтгөхөөр тохиров» гэжээ.⁵ 2011 оны 6 дугаар сард Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж АНУ-д албан ёсны айлчлал хийж, Ерөнхийлөгч Барак Обаматай уулзахад АНУ-ын төрийн тэргүүн хэлэхдээ: «Манай хоёр орны харилцаа иж бүрэн түншлэлийн хүрээнд жилээс жилд хөгжиж байгаад би сэтгэл хангалуун байдаг. АНУ Монгол Улсын хувьд гуравдагч хөрш болж байдагтай баяртай байдаг» гэж дурджээ.

Бүр 1944 оны 7 дугаар сард АНУ-ын Дэд Ерөнхийлөгч

Хенри А.Уоллес Монголд айлчлахад дагалдаж ирсэн, хошим америкийн нэрт монголч эрдэмтэн болсон О.Латтимор 1949 онд туурвисан "Ази дахь шийдэл" бүтээлдээ: «Монголыг гуравдагч орны статустай болгох нь (онцлов Д.У) Америкийн ашиг сонирхол болохсон билээ. Гэтэл энэ улс тусгаар тогтносон уу гэсэн эргэлзээ гарган Монголыг НҮБ-ын гишүүн болгохын эсрэг санал өгч алдаа хийж байна... одоо Монгол коммунистуудын захиргаатай Орос, коммунистуудын хяналттай Хятадын гунд оршиж байна. Ийм нөхцөлд Хятад, Оросын хилийн бүсэд 600 мянган хүн ам, газар нутагт нь оршиж буй энэ орны хувьд ач холбогдол өгөх нь Америкийн бодлогын хувьд давуу тал болохсон...»⁶ гэж тогдорхой бичиж байжээ.

III. «Гуравдагч хөрш»-ийн бодлогын зорилго, мөн чанар

Гадаад, дотоод орчны өөрчлөлтийн үйл явцтай холбогдон 1980-аад оны сүүлчээс Монгол Улсын гадаад харилцааны салбарт томоохон дутагдал оршиж байгааг эрх баригч МАХН анх удаа хүлээн зөвшөөрч, өөрийн бодлого, байр суурийг хурц шүүмжилж эхэлсэн билээ. Үүнд: нэгд, улс орны дотоод амьдралын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд гадаад харилцааны өргөн боломжийг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байгаа, хоёрт, гадаад улс төр, гадаад эдийн засгийн бодлогын харилцан шүтэлцээ, цогц байдлыг зөв хослуулах, гуравт, олон улсын байдал болон гадаад харилцааны асуудалд нарийн судалгаа, дүн шинжилгээтэй хандах явдал дутагдалтай, голдуу тунхаглах, лоозогнох шинжтэй байгааг шүүмжлээд үзэл суртал, бусад ялгааг шалтаг болохгүйгээр өндөр хөгжилтэй Өрнөдийн орнуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг тогтоон хөгжүүлэх нь цаг үеийн бодит байдалд нийцсэн олон улсын харилцааны ирээдүйтэй хандлага болсныг цохон тэмдэглэсэн юм. Монгол Улс 1961 онд НҮБ-ын бүрэн эрхт гишүүн болсон нь Өрнө дахинтай харилцаагаа тогтоон хөгжүүлэх шинэ боломжийг нээсэн хэдий ч, энэ боломжийг дүүрэн ашиглаагүйгээр зогсохгүй хүйтэн дайны улмаас НҮБ-ын индэр эсрэг, тэсрэг хоёр системийн үзэл суртлын тэмцлийн талбар болж, Монгол Улс ч түүнд татагдан оролцож байв. Харин улс төр, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаагаа

бүх салбарт иж бүрэн хөгжүүлэх боломж жинхэнэ утгаараа хүйтэн дайны төгсгөл үед тохиов.

Тийнхүү Монгол Улс үндэсний язгуур эрх ашгийг дээдлэсэн, энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлого явуулсан нь хоёр хөрштэйгөө тэнцвэртэй харьцах боломж олгож, Өрнө, Дорнын олон улс орнуудтай түншлэлийн цоо шинэ харилцааг буй болгов.

Монгол Улсын гадаад харилцаанд буй болсон шинэ хүчин зүйл нь хоёр хөршөөс гадна дээр дурдсан АНУ, Япон, Өрнөд Европ зэрэг дэлхийн бодлогод шийдвэрлэх нөлөөтэй зонхилох орнууд, олон улсын байгууллагууд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх болсон явдал мөн. Үүний үндсэн уг сурвалж нь Монголд гарсан ардчилсан өөрчлөлт, зах зээлийн эдийн засагт шилжих үйл явц байсан бөгөөд тэдгээр орнууд ч Монгол Улсыг ардчилсан шинэ тогтолцоонд шилжихэд бүх талын дэмжлэг үзүүлэх, нөгөө талд урд, хойд хоёр хөршид нь шилжилтийн амжилттай даван туулж буйг жишээ болгон харуулах давхар зорилго ч агуулж байсныг тэмдэглэх хэрэгтэй.

Улс төрийн шинжлэх ухаан, олон улсын харилцааны онол, геополитик судлалд «гуравдагч хөрш»-ийн тухай ойлголтыг тусгайлан тодорхойлсон зүйл одоогоор хараахан гараагүй байгаа юм. Энэ утгаараа Монгол Улс бага, жижиг орны гадаад бодлого дахь «гуравдагч хөрш» хийгээд «гуравдагч хөрш»-ийн бодлого хэмээх шинэ ухагдахууныг буй болгон хэрэгжүүлж байгаа нь улс төрийн шинжлэх ухаан, олон улсын харилцааны онол, геополитик судлалын судлагдахууныг баяжуулж буй хэрэг гэж үзвээс зохилтой.

1994 онд батлагдсан Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалд «гуравдагч хөрш» хийгээд «гуравдагч хөрш»-ийн бодлого, түншлэлийн талаар тусгайлан заагаагүй боловч 2010 онд шинэчлэн батлагдсан "Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-д «"Гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд өндөр хөгжилтэй ардчилсан улсуудтай улс төр, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлнэ»⁷, харин 2011 онд шинэчлэн батлагдсан "Гадаад бодлогын үзэл баримтлал"-д

«АНУ, Япон, Европын Холбоо... зэрэг өрнө, дорнын улс, холбоотой "гуравдагч хөрш"-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх»-ээр⁸ анх удаа бодлогын хэмжээнд тус тус заажээ. Харин шинэчлэн батлагдсан "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-д Холбооны [Европын Д.У] талаар заагаагүй байна. Үзэл баримтлалаас харахад Монгол Улсын «гуравдагч хөрш» гэдэгт нэгд, өндөр хөгжилтэй, хоёрт, ардчилсан улс, холбоо гэж ойлгогдож байгаа юм. «Гуравдагч хөрш»-ийн бодлогын хүрээ гэдэгт улс төр, аюулгүй байдал, эдийн засаг, соёл, хүмүүнлэгийн салбарт хоёр болон олон талт харилцаа, хамтын ажиллагааг хэлж байна. Бидний хувьд Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийг илүү өргөн утгаар нь авч үзвэл олон улсын энхтайван, аюулгүй байдлыг сахин хангах, нийт хүн төрөлхтний өмнө тулгамдсан нийтлэг асуудлыг авч хэлэлцдэг, хөгжиж буй орнуудын тогтвортой хөгжлийг дэмжих зорилготой дэлхийн хамтын нийгэмлэг НҮБ ч орох учиртай. НҮБ бол хөгжиж буй улс орнуудын нийтлэг эрх ашгийг илэрхийлдэг, мөн хамгаалдаг, хөгжил дэвшилд тус дөхөм үзүүлдэг, Монгол Улс ч тэр, АНУ ч тэр хоёул адилхан нэг, нэг саналтай ийм түгээмэл байгууллага болой.

Монгол Улсын ГХЯ Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлого нь биеэ даасан үзэл баримтлал байх ёстой гэж үзэж 2003 онд өөрийн саналыг ҮАБЗ-д оруулж байсан бөгөөд түүний гол үзэл санаа нь шинэчлэгдсэн Гадаад болон Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд үндсэндээ тусгагджээ.

Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлого нь тус улс үндэсний эрх ашгийг дээдлэсэн, энхийг эрхэмлэсэн, олон тулгуурт, нээлттэй, бие даасан гадаад бодлого явуулж буйн тод илрэл юм.

Монгол Улс өөрийн хүрээлэн буй геополитикийн орчинд хэрэг дээрээ «гуравдагч хөрш»-тэй болж, түүний эрхзүйн үндсийг бүрдүүлсэн гэж үзэж болохоор байна. Монгол Улс 1997 онд Японтой «Иж бүрэн түншлэл», 2010 онд «Стратегийн түншлэл», 1999 онд БНСУ-тай «Харилцан нөхсөн хамтын ажиллагаа, хөгжлийн түншлэл», 2006 онд «Сайн хөршийн найрамдал, хамтын ажиллагааны түншлэл», 2011 онд «Иж бүрэн түншлэл», 2004, 2005 онд АНУ-тай «Стратегийн

түншлэл», 2004 онд Канадтай «Өргөн хүрээтэй түншлэл», 2005 онд Турк улстай «Иж бүрэн түншлэл», 2007 онд Австрали улстай «Өргөтгөсөн түншлэл», 2007 онд Казахстантай «Өргөн хүрээтэй түншлэл», 2008 онд ХБНГУ-тай «Иж бүрэн түншлэл», 2009 онд Энэтхэгтэй «Иж бүрэн түншлэл», 2011 онд Украинтай «Олон талтай хамтын ажиллагааны түншлэл», 2013 онд ЕХ-той «Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээр»-ийн харилцааны эрхзүйн баримт бичгүүдийг тус тус байгуулав.

Бүр 1995 онд Өрнөд Европын орнуудаас анх удаа Европын Холбооны жинтэй, нөлөө бүхий гишүүн, ХБНГУ-тай «Монгол Улс, ХБНГУ-ын харилцааны үндсийн тухай Тунхаглал», 1996 онд Францтай «Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны хэлэлцээр» байгуулж, Австрали улстай «Найрамдал, хамтын ажиллагааны тухай хамтарсан мэдэгдэл»-ийг анх удаа гаргасан нь нэн ач холбогдолтой үйл явдал байв.

«Гуравдагч хөрш», «түнш», «түншлэл» хэмээх нэр томъёо нь 1990-ээд оны эхнээс олон улсын харилцааны хэллэгт бодлогын шинжтэй, шинэ агуулга, хэлбэртэйгээр баттай орж ирэв. Өнөөдөр «стратегийн түншлэл», «энхийн төлөө түншлэл», «гуравдагч хөрш», «иж бүрэн түншлэл» «түншлэл, хамтын ажиллагаа», «хөгжлийн түншлэл», «оюун санааны хөрш» буюу түншлэл, «өргөн хүрээтэй түншлэл», «олон талтай хамтын ажиллагааны түншлэл» «тэгш эрхтэй түншлэл» гэх мэт нэр томъёо нь олон улсын харилцааны баримт бичгүүд, эрдэмтэн судлаачдын бүтээл зэрэгт өргөн дэлгэр тусгагдаж, мөн улс төрийн зүтгэлтэн, эрдэмтэн судлаачид сайхь нэр томъёог өөр өөрсдийн ашиг сонирхлын үүднээс нарийн ширийн шигтгээ оруулан үйл явцын өрнөлтөд тохируулан тайлбарласаар байна.

Түншлэлийн харилцаа нь хамтын ажиллагааны ямар нэг хатуу тогтсон үзэл сурталд тулгуурладаггүй, харин улс орнуудын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, дотоод хэрэгт үл оролцох, тэгш эрхтэй, харилцан ашигтай, хөгжлийн нийтлэг эрх ашиг, сонирхлыг тэргүүн зэрэгт тавих, улс бүрийн ялгаатай соёл иргэншил, амьдралын ёс жаягийг ойлгон хүндэтгэх, зөвшлийн үндсэн дээр шийдвэр гаргана гэж үйл ажиллагаандаа баримтлах зарчмаа төлөв тодорхойлж байна. Тэгэхлээр түншлэл нь «гуравдагч хөрш»-

ийн бодлогын хүрээнд "иж бүрэн" байж болно, "стратегийн" байж болно, "олон талтай", эсвэл "өргөн хүрээтэй" байж болно, мөн "оюун санааны" түншлэл байж болно. 2011 оны 8 дугаар сард Финландын Ерөнхийлөгч Тарья Халонен Монголд айлчлах үеэрээ хоёр орны харилцааг «тэгш эрхтэй түншлэлийн харилцаа» гэж нэрлэж байв. 2007 оны 4 дүгээр сард Австралийн Гадаад харилцааны сайд А.Даунер Монгол Улсад албан ёсны айлчлал хийх үеэр хоёр улс «өргөтгөсөн түншлэл»-ийн зарчмаар харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх талаар тохиролцсон билээ. Өөрөөр хэлбэл, хоёр тал ямар бодол, сонирхолтой байгаагаасаа хамааран түншлэлийн харилцаагаа янз бүрээр тодотгож, томъёолон гаргаж ирж байгаа ч утга агуулга нь хоорондоо адил төстэй юмуу, ижил байдаг. Зарим орон «стратегийн» гэдэг үгнээс зайлсхийдэг. «Стратегийн түншлэл»-д уламжлалт болон уламжлалт бус аюул, түүний аюулгүй байдлын асуудал, энхтайвныг сахин хангах, олон улсын терроризмын эсрэг тэмцэх, чөлөөт худалдааны хэлэлцээр гол төлөв тусгагдсан байдгаас гадна гол нь энэ харилцаа урт хугацаанд тогтвортой үргэлжилнэ гэсэн санаа хамт явж байдаг байна. Харин энд "холбоотны буюу эвслийн" эрх ашгийг тэргүүн зэрэгт тавих буюу харгалзах, «ах дүүгийн» харилцааны ах нь сургах, дүү нь сонсох агуулга суурилдаггүй бөгөөд үүгээрээ түншлэгч талуудын тэгш эрх хангагдаж буй гэж үзэж болно. Мөн өргөн хамтран ажиллах утга санаа шингэсэн байдаг нь хамтын хариуцлага хүлээдэг. Тэгэхлээр түншлэл нь улс гүрнүүдийн хэвийн, найрсаг харилцаанаас агуулга, хэлбэрээрээ өргөн юм.

Зарим улс орон стратегийн түншлэлийн харилцаанд болгоомжтой ханддаг ч орчин үеийн олон улсын харилцааны шинэ дэг журам бүрэлдэн тогтох үйл явц өрнөж байгаа өнөө үед түншлэл нь гуравдагч этгээдийн эсрэг чиглэсэн шинж байх ёсгүй. Даяаршлын одоо үед түншлэлийн эдийн засгийн утга, агуулга нь улам өргөжин тэлж байна. Нөгөө талд Монгол Улсын орон зайн байршил, байгалийн баялаг хоёр геополитикийн гол хүчин зүйл болов.

Гуравдагч хөрш»-ийн тухай ойлголт нь шинэ тутам гарч ирсэн үзэл санаа биш юм. Монгол Улс түүхэндээ «гуравдагч хөрш»-өө эрж хайж байсан цаг үе ХХ зууны эхний хориод

жилд холбогддог бөгөөд харин ингэж цэгцтэй ойлгох, бодлогын түвшинд томъёолох талаар оролдлого хийж байгаагүй нь мэдээж.

«Аливаа улсын гадаад бодлого нь оршин буй газарзүйгээрээ тодорхойлогдоно» гэж Наполеон Бонапарт хэлжээ. Энэ үг газарзүйн онцлог байршилтай Монгол Улсад ихээхэн хамаатай. Улс гүрэн бүгд нэг нь нөгөөтэйгээ айл хөрш болж зэрэгцэн оршдог. Германы геополитикч, профессор Фридрих Ратцелийн (*Friedrich Ratzel 1844-1904*) «хөршөө сонгодоггүй» гэж хэлсэн нэгэн үг буй. Энэ бол зөвхөн хил залгасан орны тухайд өгүүлж буй хэрэг юм. Харин сайн хөршийн харилцааны тухайд бол түүнийг заавал айл зэргэлдээ гэхгүй алс холын аль ч оронтой тогтоож болно. Энэ утгаараа хөрш нь хаяа нийлсэн хэдэн ч орон байж болох бөгөөд харин хил залгаагүй хөршөө бол сонгож болох ажгуу.

«Гуравдагч хөрш»-ийн бодлого гэдэг нь зөвхөн газарзүйн бодлого, ойлголт бус, тухайлсан нэг улсад хандсан бодлого ч бус, харин улс төр, эдийн засаг, геополитик, аюулгүй байдлын хүрээг хамарсан газарзүйн байршил, орон зайн онцлогоос үүдэн гарсан олон улсын харилцааны онолын ухагдахуун хэмээн үзвээс зохистой. Хөрш гүрнүүдээс явуулж буй бодлого, үйл ажиллагааны төвд зохистой хүчний тэнцвэрийг удаан хугацаанд хангах, хадгалах, саармагжуулахад чиглэгдсэн үндэсний аюулгүй байдлаас шууд үүдэн гарсан хөгжиж буй бага жижиг улсад хамаатай геополитикийн бодлого бөгөөд Монгол Улсын ардчилал, зах зээлийн эдийн засгийн бодлогыг тууштай дэмжигч Өрнө, Дорнын ардчилсан, хөгжингүй орнууд болон НҮБ зэрэг дэлхийн бодлогод жин нөлөөтэй субъектыг оруулж буй өргөн хүрээтэй ойлголт гэж тодорхойлж болохоор байна.

Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлого нь эвсэл, холбоотны бодлого биш, хоёр хөршийн эсрэг чиглэсэн бодлого ч биш, мөн зөвхөн энхтайван цагийн геополитик гэдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

«Гуравдагч хөрш»-ийн бодлогын онолын үндэс нь хүчний тэнцвэр (*balance of power*) болно. Гадаад бодлого бол өөрөө батлан хамгаалах том арга хэрэгсэл юм.

«Гуравдагч хөрш»-ийн бодлого нь дан гагц нэг талын

урсгалтай бус, тэдгээр орнууд ч Монгол Улсын «гуравдагч хөрш» гэсэн итгэл үнэмшилтэй байх явдал чухал гэдэг нь мэдээж. Гэхдээ улс орнууд бусдын өмнөөс илүү үүрэг хариуцлага хүлээх, өөрсдийн нуруун дээр илүү ачаа үүрэхээс байнга зайлсхийдэг.

Харилцан хамаарал гүнзгийрч, олон улсын харилцааны өөрчлөгдөн буй даяаршсан дэлхий ертөнцөд аливаа бага, жижиг улс орны оршин тогтнох, хөгжин дэвших, үндэсний аюулгүй байдлаа хангах нь гагц цэрэг-стратегийн асуудалтай холбогдохгүй, харин худалдаа, хөрөнгө оруулалт, зээл, тусламж, байгаль орчинд ээлтэй тогтвортой хөгжил, ядуурлыг бууруулах, ардчилал, ухаалаг засаглал, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, шинжлэх ухаан-технологи, мэдээллийн технологийн үр нөлөөлөл, далайд гарцгүй байршил болон улс орнуудын хоёр болон олон талт хамтын ажиллагаа зэрэгтэй уялдаж өргөн утгыг агуулах болсон байна. Энэ нь «гуравдагч хөрш»-ийн тухай ухагдахууныг тэлж байгаа хүчин зүйл юм.

«Гуравдагч хөрш»-ийн бодлого нь үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн эрх ашгийн тухай асуудал юм. Хөгжлийн асуудал тэргүүн зэрэгт тавигдаж буй өнөө үед улс орнуудын аюулгүй байдал, тусгаар тогтнол, гадаад эдийн засгийн харилцаа, түүнээс гарах үр өгөөжтэй амин чухал холбоотой. Энэ утгаараа сайхь бодлого нь гадаад харилцааг эдийн засагжуулахтай уядах учиртай нь мэдээж. Монгол Улсын эдийн засгийн дипломат ажиллагааны үндсэн зорилго нь гадаад харилцааны арга хэрэгслээр эдийн засгийн өгөөжийг дэмжихэд оршино. Өөрөөр хэлбэл, ДНБ-ий өсөлтөд гадаад бодлого, дипломат ажиллагааны оруулах хувь нэмрийг тууштай нэмэгдүүлж, шууд болон шууд бус үйлчлэлтэй болгох явдал юм.

2006 онд ГХЯ-наас эрхлэн гаргасан "Гадаад бодлогын хөх ном"-д «Монгол оронд тохиож болох нийгмийн тогворгүй байдал, улс төр-эдийн засгийн хямрал, улс төрийн засаглалын гэнэтийн өөрчлөлт, байгалийн гамшиг бэрхшээл, далайд гарцгүй байдал зэрэг сөрөг хүчин зүйлийг даван туулахад энэхүү үзэл баримтлал чухал үүрэгтэй гэсэн санааг ч бодолцох учиртай» гэсэн байна.

БНСУ, Бельгийн Вант улс болон ЕХ-ны дэргэд, Турк, Канад,

Австри, Австрали, Сингапур, Шведийн Вант улс, Кувейт, Италид Монгол Улсын ЭСЯ-ыг шинээр эмхлэн байгуулсан нь «гуравдагч хөрш»-ийн бодлогын хүрээнд эдийн засгийн эрх ашгийг тэргүүн зэрэгт тавьсан хэрэг мөн. 2011 онд Монгол Улс Ром хотноо ЭСЯ-аа нээснээр Их наймын бүх орнуудад байнгын дипломат үйл ажиллагаа явуулах боломжтой болов.

1990-ээд оноос гадаад бодлогод гарсан өөр нэг шинэ чиглэл бол Өргөмжит консулын институт буй болж, 40 гаруй оронд 60 орчим Өргөмжит консул Монгол Улсын эрх ашгийг хилийн чандад төлөөлж байна. Гадаадад монгол иргэд олноор зорчих, сурч боловсрох, ажиллаж амьдрах, хууль бусаар ажил эрхлэх нь эрчимтэй өсч буй өнөө үед иргэдийнхээ эрх ашгийг хамгаалж ажиллах, тодорхой улс орон, бүс нутагт дипломат болон консулын төлөөлөгчийн газар нээн ажиллуулах шаардлагатай ч санхүү, хүний нөөцийн боломж хязгаарлагдмал хэвээр байгаа билээ. Дэлхийн хөгжиж буй бага жижиг улс орнууд гадаад бодлогын чухал хэрэгсэл болгон ашигладаг Өргөмжит Консулын албыг Монгол Улс 1992 оноос эхлэн хэрэгжүүлж байгаа юм. Өргөмжит консулын албаны олон улсын эрхзүйн үндсэн баримт бичиг нь 1963 оны Консулын харилцааны тухай Венийн конвенци бөгөөд гадаад орнууд энэхүү конвенцийн 3 дугаар бүлгийн заалтууд болон хоёр талын хэлэлцээр, дотоодын хууль журмыг удирдлага болгон мөрддөг. Энэ бол «гуравдагч хөрш»-ийн бодлогын бүрэлдэхүүн хэсэг гэж хэлж болно.

«Гуравдагч хөрш»-ийн бодлогын улс төр, аюулгүй байдал, худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-технологи, инноваци, соёл, боловсрол, хүмүүнлэгийн хүрээ, хэрэгжүүлэх гурвалжин-дөрвөлжин механизм гэсэн асуудлууд байгаа юм.

IV Хэрэгжүүлэх механизмын талаарх зарим бодрол

Монгол Улсын хойд хөрш дэлхийн хамгийн том газар нутагтай, цөмийн зэвсэгтэй сэргэн мандаж буй гүрэн бол, урд хөрш дэлхийн хамгийн олон хүн амтай, цөмийн зэвсэгтэй, үсрэнгүй урагшилж буй эдийн засагтай хамгийн том хөгжиж буй орон, мөн хоёул өөрсдийн бие даасан бодлого, байр суурьтай их гүрнүүд юм. Монгол Улс ийм өвөрмөц геополитикийн байршилтай цорын ганц орон гэж хэлж болно.

Монгол Улс хоёр хөрштэйгээ тэнцвэртэй харилцах гадаад бодлогын тэргүүлэх зарчмыг удирдлага болгон 2003 онд ОХУ-тай «Сайн хөршийн уламжлалт түншлэл», 2009 онд «Стратегийн түншлэл», 2003 онд БНХАУ-тай «Сайн хөршийн харилцан итгэсэн түншлэл», 2011 онд «Стратегийн түншлэл»-ийн харилцааны эрхзүйн үндсийг тавьсан нь «гуравдагч хөрш»-ийн бодлогыг хэрэгжүүлэх чухал нөхцөл мөн.

Монгол Улсын Дипломат албаны хууль, Гадаад бодлогын үзэл баримтлалд заасан гадаад бодлогын нэгдмэл байдлыг хангаж, залгамж чанарыг хадгалах тухай заалтыг шийдвэр гаргах бүх түвшинд тууштай баримтлах явдал нэн чухал. Хоёр хөрштэй харилцах гадаад бодлогын тэргүүлэх чиг шугамыг умартах, уламжлалт түнш, найрсаг харилцааны түвшинг үгүйсгэх, хоёр хөршийн харилцааны тухайд үл ойшоосон болчимгүй байр суурь баримтлах нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд таатай нөлөө үзүүлэхгүй нь ойлгомжтой.

Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлого төрийн бодлого хийгээд хоёр талт харилцаа, хамтын ажиллагааны эрхзүйн баримт бичигт тусгагдаж, баталгаажиж байгаагаас гадна, мөн дээрхийг хэрэгжүүлэх олон талт хамтын ажиллагааны байнгын механизм байгуулж өргөжүүлэх нь илүү үр дүнтэй байх болов уу. Монгол Улс гурвалсан яриа хэлэлцээний байнгын институцитэй болох чиглэлд зохих алхам хийж буй бөгөөд энэ нь хөрш хоёр гүрний бодлого, байр суурийг илүү тодорхой ойлгож мэдэх, өөрийн улсын бодлого, байр суурийг илүү ойлгомжтой тайлбарлаж, дэмжлэг авахад нэн ач холбогдолтой. Хөрш гурван улсын ГХЯ-д хоорондын 8 дахь удаагийн зөвлөлдөх уулзалт Улс төрийн газрын захирал нарын түвшинд 2012 оны 10 дугаар сард Москва хотноо болов.

Анх удаагаа албан ёсны статустайгаар болсон гурван талын зөвлөлдөх уулзалт цаг хугацааны сорилтыг амжилттай давж, хоёр талын болон олон талт хамтын ажиллагааны харилцан сонирхсон асуудлыг хэлэлцэх зохистой талбар болсон хэмээн талууд санал нэгтэй үзэв. Монгол, Орос, Хятадын хооронд улс төрийн болон түүхийн аливаа шийдэгдээгүй асуудал байхгүйг талууд цохон дурдахын сацуу бие биенийхээ тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хүндэтгэх үндсэн дээр бүс нутгийн аюулгүй байдлыг

бэхжүүлэх нь зүйд нийцнэ хэмээн үзэв. Талууд гурван талт хамтын ажиллагааны хөгжлийг нааштайгаар үнэлж, Монгол, Орос, Хятадын харилцан ажиллагааны тэргүүлэх чиглэл, түүнчилэн бүс нутгийн болон олон улсын асуудлаар санал бодлоо нухацтай солилцсон байна.

Гурван талын зөвлөлдөх уулзалт уул уурхайн салбар, дамжин өнгөрөх тээврийн гурван улсын нөөцийг хамтран ашиглах, дэд бүтцийн бүтээн байгуулалт, аялал жуулчлал, байгаль орчин, хүмүүнлэгийн солилцоо зэргийг талуудын харилцан сонирхолд нийцсэн хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл хэмээн тэмдэглэв. Үүн дээр хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилсан дипломат ажиллагаа, хямралын менежментийн асуудлыг нэмж оруулах нь зүйтэй. Цаашдаа эхний үе шатанд гурван улсын Гадаад харилцааны сайд нарын уулзалтыг зохион байгуулж, үүний дараах үе шатанд ойрын ирээдүйд хоёр хөрш+1 гэсэн парадигм уулзалтыг санаачлан хэрэгжүүлж болох юм. Өөрөөр хэлбэл гурвалсан уулзалт+«гуравдагч хөрш» гэсэн дөрвөн талын өөрөөр хэлбэл АСЕАН+3 шиг дээд уулзалтыг зохион байгуулж хамтын ажиллагааны байнгын механизм буй болгох чиглэлээр ажиллаж болох юм. Монгол Улс «гуравдагч хөрш»-ийн бодлогын мөн чанарыг НҮБ-ын хэмжээнд тайлбарлан таниулах, юун өмнө хоёр хөршид дээд түвшинд ойлгуулж, албан ёсны хүндэтгэл авах явдал чухал болой. Мэдээж энэ бүгд нь идэвхтэй дипломат ажиллагаа, хүчин чармайлт, цаг хугацаа шаардана. 2013 оны 10 дугаар сарын 25-нд Монгол Улсын Ерөнхий сайд Н.Алтанхуягийн БНХАУ-д хийсэн айлчлалын үеэр БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд Ли Кецяны хамт гарын үсэг зурсан «Монгол Улс, БНХАУ-ын хооронд стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх Дунд, Урт хугацааны хөтөлбөр»-ийн тавын 5-д: «Талууд Монгол Хятад, Оросын гурван талын зөвлөлдөх уулзалтын механизмыг үргэлжлүүлэн бэхжүүлэх, дэд сайдын түвшний зөвлөлдөх уулзалтын механизмыг байгуулах асуудлыг урагшлуулахаар санал нэгтэй тохиролцов. Шаардлагатай тохиолдолд гурван талын өндөр түвшний уулзалт зохион байгуулж, Монгол, Хятад, Орос гурван улсын хамтын ажиллагааг улам бүр урагшлуулна»⁹ гэж заасан нь чухал ач холбогдолтой.

V. Монголын дипломатын түүхэн гэх «гуравдагч хөрш»-ийн үзэл санаа

Геополитикийн үүднээс шинжилж үзвэл Монгол шиг цэрэг-улс төр, эдийн засгийн үлэмж чадавхтай, дэлхийд хамгийн олон хүн амтай, мөн дэлхийд хамгийн том газар нутагтай, цөмийн зэвсэгтэй хоёр их гүрний дунд орших, далайд гарцгүй, түүнчлэн монгол угсаатнаар хүрээлэгдсэн өвөрмөц газарзүй-орон зайн байршилтай орон байхгүй юм. Олон зуун жилийн туршид геополитикийн хүрээгээ ямагт тэлж, дэлхийн бодлогод нөлөөлсөөр ирсэн хоёр хөрш Монголчуудын түүхэн хөгжлийн тодорхой үе шатанд олон талаараа шууд болон дам нөлөө үзүүлж, эгзэгтэй үед Монголын хувь заяаг тусдаа хийгээд хамсан нийлж байгаад шийдвэрлэж байсан нь түүхэн үнэн билээ.

1911 оны тусгаар тогтнолын сэргэлтийн дараа Монголын удирдагчид хоёр хөршөөсөө гадна «гуравдагч хөрш»-тэй харилцаа тогтоохыг чинхүү эрмэлзэж байсан нь гадаад улс төр, эдийн засгийн бодлогын чухаг чиг шугам байжээ. Энэ нь юуны өмнө Өрнө, Дорны гүрнүүдээр тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх, улмаар тэдгээр орнуудтай худалдааны өргөн харилцаа холбоо тогтоох, Өвөрлөгч нутгийг Халхад нэгтгэх замаар Монгол үндэстний улс төрийн нэгдлийг хангах, түүнийгээ бататгах үндэсний эрх ашиг хийгээд аюулгүй байдалтай ямагт холбогдож байв. 1912 оны 11 дүгээр сард Монгол Улсын ГХЯ-наас ноот бичиг үйлдэн «Их Фа (Франц), Ин (Англи), Дэ (**Герман**), Мэй (АНУ), Билиш (Бельги), Бин (**Япон**), Дан Ма (Дани), Хэ Лан (Голланд), Ау (Австри) зэрэг есөн гүрний ГХЯ-нд илгээжээ. Түүнд:«... дурьдсан улсын Засгийн газруудтай дипломат төлөөлөгчид солилцож, ... харилцан гэрээ байгуулж, худалдаа нэвтрүүлж, улсын найрамдлыг зузаатгамуу»¹⁰ гэсэн саналыг дэвшүүлж байв. Энэ ноот Монгол Улсаас их гүрнүүдэд хандсан албан ёсны анхны баримт бичиг юм.

Нэг сарын дараа Богд хаанаас хичээнгүйлэн Их Фа, Ин, Дэ, Билиш, Хэлан зэрэг таван улсын эзэн хааны амгаланг эрж, үүрд сайнаар найрамдахыг хүссэн албан бичгийг ч илгээжээ. Үүнийгээ 1913 онд Ерөнхий сайд, Сайн ноён хан

Т.Намнансүрэн Санкт-Петербургт айлчилахдаа болон 1914 онд ГЯЯ-наас Бээжин дэх Өрнөдийн орнуудын ЭСЯ-дад илгээсэн ноот бичигт дахин нотолжээ.

1913 оны эхээр Дотоод яамны тэргүүн сайд сүжигт чин ван да лам Цэрэнчимэд, Бүгд ерөнхийлөн захирах яамны дэд сайд бинт чин ван Гончигсүрэн нар Токио орохоор морьдож, Богд хааны захидал бичгийг Японы цог жавхлант Эзэн хаанд биеэр хүргэх, утга нь Монголын улс төрийн нэгдлийг хангахад туслах, Өвөр Монголыг эвээлдээ авах, тусгаар тогтнолоо зөвшөөрүүлэх, худалдааны өргөн харилцаа тогтоох агуулгатай байв.

Дурдсан үед Богд гэгээний Засгийн газрын (King and His Holliness VIII Bogdo Jabtsundamba khutukhtu Government) дипломатын талаар олсон амжилтын чухаг хэсэг нь Түвдтэй байгуулсан 1913 оны есөн зүйлт Гэрээ бичиг мөн.¹¹ Их гүрнүүд олон улсын харилцааны хэрэг явдлыг ил, далд элдэв аргаар бүхэлд нь шийдвэрлэж байсан тухайн үед бага буурай хоёр улс, ард түмэн бие биеийнхээ тусгаар тогтсоныг ***de jure харилцан хүлээн зөвшөөрч, найрамдлын барилдлага, харилцан туслалцах холбоотны гэрээ байгуулж байсан*** нь бараг ховор юм. Үүгээрээ сайхь гэрээ нь олон улсын харилцаа, дипломатын түүхэнд шинэ зүйл болсон гэж үзвээс зохилтой бөгөөд Олноо өргөгдсөн (All elevated) Богд хаант Улсаас түүх, соёл, шашин шүтлэг нэгт «гуравдагч хөрш»-тэй байгуулсан анхны эрхзүйн баримт бичиг байв.

1915 оны Хиагтын гурван улсын Гэрээгээр Монгол Улсын тусгаар тогтнолыг хязгаарлаж, Хятадын хэмжээт эзэрхэл (сюзернитет), Оросын хамгаалал (протекторат) дор автономит улс болж, тус орны дотоод, гадаад улс төрийн амьдрал ээдрээ төвөгтэй болсон, Европт дэлхийн I дайн эхэлсэн нь Хаан Оросын Алс Дорнод дахь нөлөө ялангуяа Монголд мэдэгдэхүйц буурсан нь Хятадын тийм нөлөө Монголд тэр хэмжээгээр өсөхөд хүргэж байв. Ийм түүхэн эгзэгтэй нөхцөлд Жалханз хутагт Дамдинбазар, Дилав хутагт Жамсранжав нарын зэрэг нөлөө бүхий ноёд Америкийг түшиглэх санаа гаргаж энэ нь Богд хааны дэмжлэг хүлээж байсан бөгөөд үүний мөрөөр Бээжин, Өргөөд америкийн дипломатуудтай нууц уулзалтууд явагдаж байсан юм.

1921 оны үндэсний ардчилсан хувьсгал ялсны дараа 9 дүгээр сарын 12-нд Ерөнхий сайд бөгөөд Гадаад Хэргийн сайд Д.Бодоо Чуулалт-Хаалган хотноо Гадаад Монголыг тусгайлан хариуцаж суусан Америкийн анхны суурин консул Самуэл Сокобиныг хүлээн авч уулзан хэлэлцэхдээ Монголын үндэсний ардчилсан хувьсгал ялсны дүнд Ардын эрхт, хэмжээт цаазат засаг тогтсон үнэнхүү учир байдал хийгээд түүний гадаад, дотоод бодлогын тухай тайлбарлахын хамт өөрийн нэрийн өмнөөс АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргад (тухайн үед *Charles Evans Hughes* ажиллаж байжээ) хандсан илгээх ноотыг ноён консулд гардуулжээ.¹² Тэрхүү ноотод: **«...Америк улсын Гадаад хэргийн яамны эрхэм сайд танаа...Огоо гагцхүү тусгайлан илтгэх нь манай Богд хаан ба Засгийн газар хийгээд олны санал улсын Засгийн газраас манай Монголын Ардын Засгийн газартай эртхэнээ гэрээ байгуулан, элчин сайг суулгаж, худалдаа, арилжааг улмаар багдруулан хоёр этгээдийн ашиг тусыг хөгжүүлэхийг хүсч байгаа тул эрхэм сайг Та толилж гаруйхнаа баяртай харуу хүртээх ажаамуу»** гэжээ.¹³ Хуучин түүх бичлэгт энэхүү ноот бичгийг Америк руу яаж илгээсэн нь тун бүрхэг байсан юм.

1922 оны 8 дугаар сарын 19-нд Германы Бээжин дэх *ЭСЯ-ны худалдааны атташе*, консул Х. Гипперих (Hermann Gipperich 1859-1954), Москва дахь Германы ЭСЯ-ны зөвлөх, доктор Р.Асмис (Dr. Rudolf Asmis 1872-1953), Дорнод Европыг судлах Германы нийгэмлэгийг (*Deutsche Gesellschaft fuer Osteuropakunde-DGO*) үндэслэгч, түүхч эрдэмтэн доктор, Н.Отто (Hoetzsch Otto 1876-1946) нар нийслэл Хүрээнд ажлын айлчлал хийжээ. Монголын Засгийн газар тэдний айлчлалд ихээхэн ач холбогдол өгч, худалдааны харилцаа тогтоох, тэр ч байтугай худалдааны хэлэлцээр байгуулах хүсэлтэй байгаагаа илэрхийлж байжээ. Зочид Ерөнхий сайд жалханз хутугт С.Дамдинбазар, Ерөнхий сайдын жинхэнэ орлогч бөгөөд Сангийн сайд С.Данзан, ГЯЯ-ны сайд Б.Цэрэндорж, Цэргийн яамны сайд, Бүх цэргийн жанжин Д. Сүхбаатар лугаа уулзалт хийсэн байна.¹⁴

ХБНГУ-ын Бундес архивт шинээр олдсон нэгэн чухал эх сурвалжид Германы дипломатчдын Монголд хийсэн айлчлалын үеэр Монгол Улсын Сангийн яамны тэргүүн сайд

С.Данзангаас "ИхГерман улсаас Думдад Иргэн улсын нийслэлд суугаа Элчин сайдын яамны худалдааны хэргийн зөвлөгч Гипперих"-д 1922 оны 7 дугаар сарын 18-наар өдөрлөсөн 567 тоот албан захидал илгээжээ. Үүнд: «... **Учир байдал иймийг урьдаар илэрхийлэн гаргаж найртай сайны ёсоор мэдэгдвээс зохихын тулд тусгайлан албаны бичиг шийтгэн гаргаж эрхэм зөвлөгч танд мэдтүгэй хэмээн явуулаад байцаан очиж бидний Монгол Улсын ийнхүү эрхэм их улс лугаа харилцан худалдаа нэвтрүүлж үүрд угтал бат зузаан найрамдахыг ихэд эрмэлзэн буй явдлыг уламжлан Засгийн газраа нэвтрүүлж, басхүү олон улсын худалдааны аргаг зарлан ухуулах ажаамуу, үүний тулд илгээв**» гээд худалдаа нь зохих хууль журмын дагуу хэрэгжихэд анхаарууштай зарим зөвлөгөөг дурдсан байна.¹⁵ Сайхь нугалбар албан бичгийн (үндсэн эх, орос, герман орчуулгын хамт) гол зорилго нь Монгол Улсын Засгийн газар Герман Улсын худалдааны пүүсүүд Монголоос мал болон ангийн гаралтай түүхий эд худалдан авч, Германаас төрөл бүрийн өргөн хэрэглээний бараа авчран худалдаалахад дэмжлэг үзүүлэх төдийгүй цаашид худалдааны харилцаа тогтоох замаар хоёр орны хооронд найрамдалт харилцааг хөгжүүлэх сонирхолтой байгаагаа Бээжин дэх ЭСЯ-аар нь дамжуулан Засгийн газарт нь хүргэх явдал байжээ.

1920-иод онд Монголын нам, засгийн удирдах зарим зүтгэлтнүүд нийгмийн байгуулал, үзэл суртлын ялгааг үл харгалзан өндөр хөгжилтэй Өрнөд Европын зарим оронтой худалдаа, эдийн засгийн харилцаа тогтоох чиглэлийг барьж байсныг 1923 оны 7 дугаар сарын 24-нд тусгай комиссоос боловсруулан нийтэлсэн "Эдийн засгийн үндсэн бодлого" хэмээх Засгийн газрын бодлогын шинж чанартай баримт бичиг басхүү тодорхой илтгэнэ.

Тухайлбал, тэрхүү баримт бичгийн 17 дугаар зүйлд: «Монгол Улсын гадаад харилцааны учир байцаавал Орос, Рибин, Америк, Англи, Герман зэргийн олон их, бага улс дотроос зарим нь хурц эрдэмтэй, зарим нь бүдүүлэг байх мэт чанар дүрс адилгүй учраас зүй нь харилцан худалдаа, ашиг, эрдэм, соёлын тухай гэрээ болзоо тогтоон нэвтрүүлэхэд хүрвэл эрх биш хэдэн давхар эргэцүүлэн хянаж тогтоовол зохино. Герман, Англи, Орос, Америк, Хятад, Рибин хэмээн

шилэх сонгоход хүрвэл аль ч талаар Герман, Орос, Америк хэмээх мэтээр дэс дараалан орох буй заа»¹⁶ гэжээ. Энэ баримт бичгийг 1923 оны 7 дугаар сард хуралдсан МАХН-ын II их хурлаас «намын программд нэмэн өргөтгөж баталсан 9 дүгээр зүйлтэй адил сацуугаар улс төрийн ба намын хэрэгт удирдлага болговол зохино»¹⁷ гэжээ.

Дээр дурдсан «Эдийн засгийн үндсэн бодлого» баримт бичгийн 18 дугаар зүйлд монгол залуусыг гадаад оронд сургахдаа гагц Орос улстай хэмээн заасангүй, харин «Урьд эдүгээ аль ч цагт орон газар хаана ч атугай эрдмээр илүү нь эрхбиш түрүүлдэг учиртайг дэлхий дээрх олон улс ухамсарлан мэдэж, эрдэмд боловсруулахыг Засгийн бодлогын манлай болгожээ» гээд улс орнуудыг боловсролын түвшингээр нь дараалуулахдаа:

«Аль улс	Хэдэн хүнээс	Бичиг үсэг үл мэдэх хэд
Герман	10000	4
Англи	10000	10
Орос	10000	7000
Рибин	10000	100

гэх мэт үлгэртэй бөгөөд эрдэм соёлоор баялаг нь эд хөрөнгө чадал хүчээр аяндаа баялаг ажгуу. Учир тийм тул эдийн засгийг үүрд бат нот арвин зузаан болгоё хэмээвээс ард түмнийг эрхбиш ерийн үсэг бичиг, утга уянга ба тусгай ашиг тус бүхий эрдмүүдэд сургахыг урьдал болговол зохино»¹⁸ гэсэн байна.

Архивын өөр нэгэн баримт бол 1926 оны 1 дүгээр сард БНМАУ-ын Ерөнхий сайдын жинхэнэ орлогч, ААЯ-ны сайд А.Амар, Бүх цэргийн зөвлөлийн тэргүүлэгч, Засгийн газрын эрхлэх товчооны гишүүн Н.Жадамбаа зэрэг төлөөлөгчид ЗХУ-д айлчилж, хоёр орны хоорондын худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тулгамдсан асуудлаар ЗХУ-ын Дипломат албаны тэргүүн Г.В.Чичеринтэй санал солилцож, албан захидал гардуулжээ.

Дурдсан захидалд: «...Үүнд эдийн засгийн тухай хэргийг улс төрийн хэрэгт холбогдуулалгүй хэлэлцэж үл болох тухай явдлыг эрхэм Танаа сануулах юун... Ихээхэн чухал болох

зүйл нь худалдаа болно.

Монгол Улсын ба мөн улсын худалдааны газрууд болбоос харъяат улсын түүхий эдийг хаана үлэмжхэн их үнэ хүргэж болох газраа нэвтрүүлэх ба гадаадаас авч ирэх барааг аль улсад боловсруулсныг хэрэгсэхгүй, гагцхүү чанар сайн, үнэ бага агаад харъяат олон ардын хэрэглэх, дурлах явдалд тавтайяа нийцүүлэхийг нь сонгон бэлтгэн авч ирнэ. Оросын аж ахуйн газруудаас эл манай худалдааны бодлогод саад боогдол учруулж устгахыг хичээх нь олон ардын туйлын ашиг тус ба манай хувьсгалт улсын аливааг үйлдэх боловсруулах хэрэг явдалд их л хор болно».¹⁹ гэсэн байдаг.

Эдгээр баримт бол Монголын удирдагчид ЗХУ-аас гадна «гуравдагч хөрш»-тэй худалдаа, эдийн засгийн хэлхээ, холбоо тогтоох чин эрмэлзэлтэй байсныг харуулж байгаа юм.

Хэдийгээр ЗХУ болон Коминтерны зүгээс БНМАУ-ын гадаад, дотоод бодлогыг өөрийн чиг шугамд захируулах арга хэмжээ авсаар байсан боловч Монголын Улс төрийн удирдах зүтгэлтнүүд нийгмийн байгуулал, үзэл суртлын ялгааг үл харгалзан өндөр хөгжилтэй АНУ, Өрнөд Европын зарим оронтой худалдаа, эдийн засаг, соёлын харилцаа тогтоон хөгжүүлэх чиглэлийг баримталсаар байжээ.

Тухайн үеийн Монголын Улс төрийн зүтгэлтнүүдийн баримталж байсан дээрх чиг шугам тодорхой амжилтад хүрснийг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

Монгол Улс 1920-иод оны эхнээс Өрнөд Европ, тухайлан Ваймерийн Бүгд Найрамдах [Герман Д.У] Улс, АНУ-тай *ad hoc* харилцаатай байсан гэж үзэж болохоор байна. Улс буюу Засгийн газрын хооронд бие биеэ харилцан хүлээн зөвшөөрөөгүй, үл зөвшөөрөх учир шалтгаантай боловч тодорхой нэгэн асуудлыг шийдвэрлэхийн тулд түр хугацаанд албан ёсны харилцаанд орох тохиолдол олон улсын харилцааны түүхэнд түгээмэл байсан бөгөөд одоо ч байгаа юм. Үүнийг дипломатын болон олон улсын эрхзүйд *ad hoc* хүлээн зөвшөөрөх гэдэг. Өөрөөр хэлбэл тухайн үед Герман, АНУ нь БНМАУ-ыг *ad hoc* хүлээн зөвшөөрсөн гэж үзэж болохоор байна.

Алс Дорнодын зүгээс гадаадын гүрнүүд цэргийн интервенц хийх үед Зөвлөлт Засгийн газар цэрэг-стратегийн

аюулгүй байдлын үүднээс 1920 онд Верхнеудинск (одоогийн Улаан-Үд) хотоор төвлөрсөн шинэ «гуравдагч хөрш» АДБНУ хэмээх «буфер»-ыг Монголтой хил залгаа чанх хойд хэсэгт байгуулж, интервенци болон иргэний дайн дууссаны дараа 1922 онд «буфер»-ээ татан буулгасан юм.

Харин 1925 онд ЗХУ, Коминтерны идэвхтэй явуулгаар БНМАУ хойд талдаа монгол угсааны эсгий туургатан Тагна-Тыва хэмээх шинэ «гуравдагч хөрш»-тэй болж, 1926 онд дипломат харилцаа тогтоожээ.²⁰ Тагна-Тывагийн нутаг дэвсгэр нь Монголын газар нутгийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг Урианхайн хязгаар байсан билээ. 1944 оны 11 дүгээр сард БНТАУ нь ЗСБНХОУ-ын бүрэлдэхүүнд нэгдэж, автономит муж болсноор хоёр улсын элчин харилцаа дуусгавар болжээ.

Нөгөө талд БНМАУ-ын дорнод хэсэгт 1932 оны 3 дугаар сард Японы идэвхтэй дэмжлэг, оролцоотой өөр нэг шинэ «гуравдагч хөрш» Манжго байгуулагдаж, тус улстай нийт 700 км урт газраар шууд хиллэх болсон нь хэрэг дээрээ Японтой хаяа хатгаж «зэрэгцэн оршиход» хүрэв. Манжго-г Герман, Японы нөлөөнд байсан болон Төв Америкийн 18 улс албан ёсоор хүлээн зөвшөөрснөөс гадна ЗХУ *de facto* зөвшөөрсөн юм.²¹ Манжго Тагна-Тыватай харьцуулахад бодлого, зорилго чиглэл нь тэс өмнөө байсан юм. Халхын сүмийн хилийн маргаанаас шалтгаан 1935-37 онд Манжго-БНМАУ-ын хооронд Манжуурт нижгээд удаа цуврал бага хурал болж, энэ үеэр дипломат харилцаа тогтоох асуудал яригдаж, 1940 оны 6 дугаар сард Манжго-БНМАУ-ын хилийн шугам тодотгох нэг талаас ЗХУ, БНМАУ, нөгөө талаас Япон, Манжго-гийн 4 талын холимог комиссын Москвагийн хэлэлцээр явагдаж 1941 оны 10 дугаар сард дуусгавар болсон, 1941 оны 4 дүгээр сарын төвийг сахих гэрээ зэргийг энд дурдаж болно.²²

1911-30 он бол Монгол Улсын гадаад харилцааны түүхэнд «гуравдагч хөрш»-тэй холбоо харилцаа тогтоохыг үнэнхүү эрмэлзэж байсан үе хэмээн үзвээс зохилтой. Гэвч үүнд саад болж байсан хүчин зүйлүүдийн гол учир нь Монгол-Оросын харилцаан дахь Хятад, Орос-Хятадын харилцаан дахь Монгол, Монгол-Хятадын харилцаан дахь Орос гэгчлэн харилцан хамааралтай боловч, ялгаатай эрх ашиг, сонирхол хосолсон гурвалжин бий болсон явдал юм. Энэхүү эрх ашиг, сонирхол

нь нэгд, хэзээ ч Хятадын бүрэлдэхүүн хэсэг байгаагүй туурга тусгаар Монгол Улсын хууль ёсны бүрэн эрхт байр суурь, хоёрт, Монголыг халхавч, бамбай байлгах гэсэн Хаант Орос, дараа нь ЗХУ-ын империйн хэдийнээс баримталж ирсэн геополитик, гуравт, Монголыг Хятадын салшгүй хэсэг гэж үзэж байсан Өмнөд хөршийн илэрхий бусармаг явуулга, байр суурь байв. Энэхүү гурвалжинд Японы хүчин зүйл тодорхой байр суурь эзэлж байсан юм. Эцэст нь, дурдсан гурвалжинд нөлөө үзүүлж байсан голлох оролцогч нь АНУ байсан гэдгийг тэмдэглэвэл зохино. Ер нь АНУ Монголын тусгаар тогтнолыг албан ёсоор шууд эсэргүүцэн татгалзсан юм уу, эсхүл энэ асуудлыг огт авч хэлэлцэхээс татгалзаж байгаагүй гэдгийг эх сурвалж нотолдог.

АНУ-аас газар нутаг, засаг захиргааны бүрэн бүтэн байдлыг хадгалах үндсэн дээр их гүрнүүд ижил нөхцлөөр Хятадад нэвтрэх тухайд явуулсан «нээлтэй хаалга»-ны бодлого 1945 оны холбоотон гурван гүрний тэргүүн нарын Ялтын бага хурлын үеэр байгуулсан нууц хэлэлцээрээр Гадаад Монголын (БНМАУ) *status quo*-г хүлээн зөвшөөрснөөр төгсгөл болсон юм. Цаашлаад 1961 онд Монгол Улс НҮБ-д гишүүнээр элсэхэд АНУ-ын бодлого, байр суурь чухал үүрэг гүйцэтгэсэн нь эдүгээ тодорхой болсон билээ.

Хүйтэн дайны үед БНМАУ социалист хамтын нөхөрлөлийн «уялдуулан зохицуулсан гадаад бодлого»-ын номлолыг тууштай баримталж, тэдгээр орнуудтай «бүх талаар ойртон нягтарч» байв. Учир шалтгааны гол нь энхтайвнаар зэрэгцэн орших зарчмын ангич, үзэл сурталжсан шинж чанар голлож байсан хүйтэн дайны үед холбоотны эрх ашгийг үндэсний язгуур эрх ашгаас дээгүүр тавьж байсанд оршино. Өөрөөр хэлбэл Монгол Улсын хувьд сонголт байгаагүй юм.

Дэлхийн II дайн дууссанаас хойш колончлолын тогтолцоо дараалан нуран унаж, 1960-аад оны эхнээс Ази, Африк, Латин Америкийн 100 гаруй орон улс төрийн тусгаар тогтнолоо олж, эдгээр улс орон эдийн засгийн тусгаар тогтнолоо бататгах чиглэлд тодорхой үйл ажиллагаа явуулж эхэлсэн хэдий ч тэдгээрийн 20 гаруй нь (Алжир, Ангол, Афганистан, Бенин, Бирм, Гвиней, Гвиней-Биссау, Зимбабе, Ирак, Конго, Ливи, Мадагаскар, Мали, Нигери, Никарагуа, Өмнөд Йемен,

Сейшеллийн арал, Сири, Танзан, Шри Ланк) 1970-аад оны дундаас ЗХУ-ын идэвхтэй дэмжлэгтэйгээр социализмыг нийгмийн хөгжлийнхөө ирээдүйн чиг баримтлал болгосон бөгөөд ЗХУ социалист хамтын нөхөрлөл (ЭЗХТЗ-ийн гишүүн орнууд) дурдсан орнуудын хувьд «гуравдагч хөрш» нь байсан гэж үзэж болохоор байдаг. БНМАУ ч тусгаар орны хувьд тэдэнд феодализмаас «капиталист бус хөгжил»-ийн замаар замнаж, социализмыг амжилттай байгуулж буй орны шилдэг жишээ, загвар орон болж байсан юм. 1970-80-аад оны энэхүү холбоотны бодлогод цэрэг-улс төр, үзэл суртлын чиглэл тэргүүлэх шинжтэй байсан гэж хэлж болно.

VI. Хөршүүдийн байр суурь

Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлогын тухайд хоёр хөрш ямар байр суурьтай байна гэдэг анхаарал татсан асуудал мөн. Өмнөд, Умард хөршүүд тааламжгүй байр суурь албан ёсоор илэрхийлж байгаагүй ч, харин олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд болон олон улсын харилцаа, геополитик, стратеги судлаачид өөрсдийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлж иржээ.

Хятадын судлаачид Монгол Улсыг худалдаа-эдийн засгийн талаар Хятад руу хэлбийсэн байдаг бол, хөрөнгө оруулалт, шинэ техник, технолгийн салбарт Япон, Канад, улс төрийн талаар АНУ-ын талыг баримталсан, цэрэг, батлан хамгаалах салбарт ОХУ-ыг түшиглэсэн шинжтэй байдаг, АНУ, Япон, Энэтхэг улстай «гуравдагч хөрш»-ийн хүрээнд стратегийн болон иж бүрэн түншлэлийн харилцаа тогтоож байгаа нь Хятадыг гурван талаас нь бүслэн хаах бодлогын илрэл юм, АНУ-ыг «гуравдагч хөрш» хэмээн үзэх болсон монголчууд үүнийгээ «олон тулгуурт гадаад бодлого» гэж нэрлэдэг нь «тогоо гурваас дээш хөлгэй байж гэмээнэ сая тогтвортой байдаг» хэмэ эх зарчим мөн болой гэхчлэн бичиж байгаа нь анхаарал татдаг. Оросууд ч Монгол дахь АНУ-ын нөлөө нэмэгдэж байгаад таатай хандахгүй байгаа нь судлаачдынх нь үзэл бодлоос ойлгомжтой харагддаг. Үүнийг А.Козыревын (1990-98 онд ОХУ-ын Гадаад хэргийн сайдаар ажиллаж байсан) Өрнөд Европыг чиглэсэн бодлогын хор уршиг гэх бөгөөд энэхүү хоосон орон зайд АНУ байр сууриа

бэхжүүлж, Монгол дахь анхаарлаа сулруулсны хар гайгаар стратегийн чухал уулын баяжуулах орос-монголын хамтарсан «Эрдэнэт» үйлдвэр болон «МонРосцветмет» нэгдлийн 51 хувь монголчуудын мэдэлд шилжчихсэн гэх мэтээр бичсэн байдаг. ОХУ-ын сүүлийн үеийн судлаачид Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлогыг Өрнөдийн орнуудтай холбоотны харилцаа тогтоох бодлогын илрэл, Оросын эсрэг чиглэсэн бодлогын чиг хандлага хэмээн бичих явдал ажиглагдаж байна.

Хоёр хөрш ОХУ, БНХАУ стратегийн түншлэлийн түвшинд харилцаагаа өргөжүүлж, БРИКС болон ШХАБ-ын хүрээнд улам бүр нягт хамтран ажиллах болов. Эрчим хүч, дэд бүтцийн салбарын хамтын ажиллагаанд Монгол Улсыг «үл оролцуулах» бодлого баримтлах хандлагатай байгаа нь анхаарал татсаар байна.

Умард, Өмнөд хоёр хөрш Монгол Улсын «гуравдагч хөрш» АНУ, ЕХ, түүний нөлөө бүхий гишүүн орнуудын хүний эрх, ардчилал, Афганистан, Ирак, Иран, Хойд Солонгосын цөмийн хөтөлбөр, Ойрхи Дорнод, арабын хувьсгал, Сири, Украин, Крым болон олон улсын харилцааны тулгамдсан асуудлаар зарим талаар зарчмын ялгаатай байр суурь баримталж байхад Япон нь ОХУ, БНХАУ-тай газар нутгийн маргаанаа шийдвэрлэж чадаагүй, БНСУ Хойд Солонгостой хуваагдмал байгаа юм.

Дүгнэлт

ОХУ, Монгол Улсын холбоотны харилцаа үгүй болж, шинээр стратегийн түншлэлийн харилцааг тогтоосон хэдий ч Монголын «буфер улс»-ын гүйцэтгэдэг геополитикийн үүрэг хэвээр, нөгөө талд ХХI зуунд Өмнөд хөршийн эдийн засаг үсрэнгүй хөгжих болсон нь сайхь улс геополитик, гео-эдийн засгийн нөлөөний хүрээгээ өргөжүүлэх өргөн боломжтой болж байгааг Өрнөдийн судлаачид «хятадын аюул» хэмээн нэрлэдэг нь огт үндэслэлгүй зүйл биш юм. Бид Монгол Улсын гадаад бодлого, түүний шийдвэр гаргах ажиллагааны шинжлэх ухаан-онол аргазүйн үндсийг улам бүр боловсронгуй болгох шаардлагатай. Хөгжиж буй улсын хөгжил дэвшил, аюулгүй байдлын баталгаажилтын чухал эх сурвалж нь идэвхтэй бөгөөд оновчтой гадаад бодлого, дипломат ажиллагаа даруй мөн. Гадаад бодлого бол өөрөө батлан хамгаалах том арга

хэрэгсэл хэмээн дээр тэмдэглэсэн.

Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн үзэл баримтлалын гол агуулга нь Монгол Улсын хувь заяа, үндэсний аюулгүй байдал болон хөгжил дэвшлийн асуудал зөвхөн хоёр хөршөөс хамаарч нөхцөлдөж байх бус, мөн дэлхийн нөлөө бүхий улс гүрнүүдийн геополитик, геоэдийн засаг, стратегийн сонирхол, оролцоо, нөлөө хамаарлаас давхар шалтгаалж байх улс төр, эдийн засаг, эрхзүйн орчинг бүрдүүлэхэд оршино. Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлого бол газарзүйн онцлог байршилтай уялдан, их гүрнүүдийн дунд хүчний зохист тэнцвэрийг барьж, үндэсний аюулгүй байдлаа улс төр-дипломат болон эдийн засгийн аргаар цогц хангах Монгол Улсын үндэсний язгуур эрх ашгаас шууд урган гарсан геополитик мөн. Нөгөө талд хоёр хөршөөс Монголын тухайд явуулж буй геоэдийн засгийн бодлого нь «гуравдагч хөрш»-ийн эрх ашгийг ямар нэг хэмжээгээр давхар хөндөж байх явдал болно.

Монгол Улсын «гуравдагч хөрш»-үүдийг бүсчлэн үзвэл Хойд Америкт: АНУ, Канад, Зүүн хойд Азид: Япон, БНСУ, Европ тивд ЕХ, түүний нөлөө бүхий гишүүн орнууд, лалын ертөнцөөс: түүх, хэл, соёлийн эртний гүн хэлхээ холбоотой, олон намын тогтолцоотой ардчилсан, их 20 бүлгийн гишүүн, ЕХ-ны гишүүнчлэлд нэр дэвшээд удаж буй Түрк, физик-газарзүйн талаасаа хамгийн ойр [жар орчим км-ын цаана] орших Казахстан, «оюун санааны хөрш» хэмээн нэрлэдэг, түүх, соёл, шашин шүтлэгийн эртний уламжлалт гүн харилцаатай Энэтхэг улсыг хамруулж байна.

Монгол Улс хоёр том гүрний дунд оршдог, далайд гарцгүй, дэлхийн зах зээлээс алслагдмал, хөгжлийн тусламж горилгоч, буурай хөгжилтэй жижиг улс байсан бол эдүгээ хоёр аварга зааны дунд орших galloper буюу чандаст хүлэг (мөн ропу гэж нэрлэдэг боловч энэ нь хангалтгүй юм Д,У) гэж хэлж болохоор, өөрөөр хэлбэл дэлхийн хамгийн хурдан хөгжиж буй бүс нутагт орших болж, эрдэс баялаг, түүхий эд, эрчим хүчний үлэмж нөөцтэй нь тодорхой болсон нь олон улсын анхаарал, их гүрнүүдийн болон үндэстэн дамнасан бизнес бүлэглэлүүдийн геополитик, геоэдийн засгийн ашиг сонирхлыг эрхгүй татаж, энэ нь томоохон шинэ боломж,

түүнчлэн томоохон шинэ эрсдлийг дагуулж байна. Үүнд уул уурхайн салбар юуны өмнө хамаарна. Байгалийн баялгийн үр шимээс ард иргэд нь тэгш хүртэж чадахгүй, эко орчин нь тэнцвэрээ алдвал тэр нь баялгийн хараал буюу **natural resource curse** болох ажгуу. Хэт ашгийн хойноос улайрагч гадны үндэстэн дамнасан хөрөнгө оруулагчдын хүсэл сонирхол, мөн ч олон улсын банк, санхүүгийн байгууллагын заавар зөвлөмж, их гүрнүүдийн нөлөө ивээл үндэсний шинээр төрж буй баяжих нэн сонирхолтой хөрөнгөлөг этгээдүүд (мөн улс төрчид) хоёрын нийлбэрийг **economic hit men** хэмээн нэрлэх болсон нь онход оргүй зүйл биш юм. Тиймээс ч «гуравдагч хөрш»-ийн бодлогын хүрээнд үүнийг сайтар харгалзан үзэх шаардлагатай болов.

Сорилт: «Гуравдагч хөрш»-бодлогын хүрээнд Өрнө, Дорны хөгжингүй, ардчилсан орнуудын Монгол дахь эдийн засгийн бодит сонирхолыг буй болгох чиг шугам тодорхой сорилтуудтай тулгарч байгааг тэмдэглэх ёстой. Тухайлбал Лондонд бүртгэлтэй АНУ-ын «Soko International PLC» компани Тамсагийн сав газарт газрын тосны хайгуул үнэлгээний ажил явуулахаар Монгол Улсын Засгийн газартай бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан ч тодорхой үр дүнд хүрсний дараа ашиглалтын лицензийг 2005 онд Хятадын төрийн өмчийн «Петро Чайна Дачин Тамсаг [Монгол]» компанид худалдсан. Цаашилбал Канадын Ванкувер хотноо бүртгэлтэй «Western Prospector Group Ltd», мөн Торонто хотод бүртгэлтэй «Khan Resources Inc.» Торонто, Нью-Йоркт бүртгэлтэй «SouthGobi Resources Ltd.» (толгой компани нь «Turquoise Hill Resources Ltd» буюу хуучнаар «Ivanhoe Mines Ltd»)-ийн салбар компани болох British Virginia-д бүртгэлтэй «SouthGobi Sands LLC», Лондон, Мельбурн хотноо бүртгэлтэй Британи-Австралийн үндэстэн дамнасан корпораци «Rio Tinto Group»-ын явуулж буй үйл ажиллагааг энд тэмдэглэх хэрэгтэй.

Гэхдээ зарим улс төрчдийн хэлж буйчлан дээрх баримт нь Монгол Улсын «гуравдагч хөрш»-бодлогын нуралт биш бөгөөд «гуравдагч хөрш»-бодлогын улс төрийн чиглэл нь тодорхойлогч шинжтэй гэдгийг онцлон тэмдэглэе.

Одоогийн байдлыг ажиглавал Монгол Улсын «гуравдагч хөрш»-ийн бодлого нь урт удаан хугацаанд үргэлжлэх

төлөвтэй бөгөөд, тиймээс залгамж шинжтэй байх ёстой.

АНУ-ын элчин сайд Жонатан Эдлтон «Нэгэн чухал хүчин зүйл: АНУ-Монгол Улсын дипломат харилцаа, 1987-2012» сонирхолтой бүтээлдээ: «Дотоод асуудал дээр ам хэлээр тохиролцож, заримдаа ширүүн мэтгэлцдэг ч гадаад бодлогын асуудлаар дэлхий нийтэд нэгдмэл байр сууриа харуулахыг хүсч буй Монголын улс төрчид үндэсний хэмжээний зөвшилцөлтэй байх хүнд ачааг зайлшгүй үүрч байна. Монгол Улсын гадаад бодлого дахь одоогийн чиг хандлагаас харахад хөрш хоёр оронтойгоо бат бэх харилцааг үргэлжлүүлэхийн зэрэгцээ шинэ томъёолол болох «гуравдагч хөрш»-өө олон янзаар хайж байна. Монгол Улс үүнийг илүү амжилттай хийх тусам цаашид улам амаргүй болж болох юм. Олон улсын тавцанд Монгол Улс ерөнхийдөө нэр хүнд ихтэй байгаа нь энэ үйл явцыг илүү хялбар болгоход тус дөхөм болно» гэсэн анхаарал татсан дүгнэлт хийсэн байна.²³

Харилцан хамааралтай болсон даяаршлын эдүгээ үед дэлхийн болон дотоодын худалдаа-эдийн засаг, валют-санхүүгийн тогтвортой байдал Монгол Улсын хөгжил дэвшил, үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөлж байна. Ойрхи үеийн томоохон сорилт нь дэлхий түүхий эдийн зах зээл дээрх Монгол Улсын экспортын гол нэрийн бүтээгдэхүүн зэс, алт, нүүрс, импортын шатахууны үнийн өөрчлөлт, валютын ханшны хэлбэлзэл, цаг уурын өөрчлөлт, байгалийн гамшиг, уламжлалт бус шинэ өвчний цар тахал, эдийн засгийн ухаалаг зөв бодлого, ардчилал, сонгуулын тогтолцоо, засаглалын хямрал зэрэг болно. Тиймээс «гуравдагч хөрш»-ийн бодлогын хүрээнд урьдчилан сэргийлэх дипломат ажиллагаа (*preventive diplomacy*), хямралын менежмент (*crisis management*) нэн чухал. Эдийн засгийн шинжлэх ухаанч бодлого, ардчилалын чанарын хэмжүүр болсон хүний эрхийн баталгаажилт, хууль дээдлэх, шударга ёсыг хэрэгжүүлэх, олонх нь цөөнхөө хүндэтгэх, ухаалаг засаглалыг цогцлоох нь амин чухал гэдэг нь ч тодорхой.

Даяаршлын үйл явцад улс орны бүх салбар хамрагдаж, харилцан хамаарал үндэсний аюулгүй байдлыг тодорхойлогч нэг томоохон хүчин зүйл болов. Ийм түүхэн үед улс хоорондын харилцаанд эрх тэгш байх, шударга байх, олон

хэлбэртэй байх, хамтын хариуцлага хүлээх зэрэг үндсэн зарчмын ач холбогдол өсч байна. Даяаршлын боломж бол хамтран ажиллаж, хамтаар хожих явдал мөн.

Өнөөдөр өөрсдийгөө буурай хөгжилтэй бага, жижиг улс, хоёр их гүрний дунд хавчуулагдсан sandwich, дэлхийн зах зээлээс алслагдсан, хөгжлийн зээл, тусламж горилогч гэх зэргээр бичиж, тайлбарлаж ирсэн үзэл баримтлал нэгэнт хуучирав.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

¹ "Ардын эрх". 1990.07.27

² "Ардын эрх". 1998.05.04

³ Монгол Улс-АНУ-ын Хамтарсан Мэдэгдэл. "Гадаад Харилцаа" ГХЯ-ны мэдээллийн товхимол. 2004. 07.30

⁴ "Өнөөдөр". 2005.11.24

⁵ Мөн тэнд

⁶ Owen Lattimore. The Solution in Asia. Boston., 1949, p. 226

⁷ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2010

⁸ Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал. УБ., 2011

⁹ Монгол Улс, БНХАУ-ын хооронд Стратегийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх Дунд, Урт хугацааны Хөтөлбөр. УБ.: 2013.10.25

¹⁰ Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл. Баримт бичгийн эмхтгэл (1910-1914), УБ., 1982, 61 дэх тал

¹¹ ГХТА. Ф-4. ХН-658. Б-2. Монгол-Түвдийн 1913 оны Гэрээ бичиг

¹² Campi A.J, Baasan R. The Impact of China and Russia on United States- Mongolian Political Relations in the Twentieth Century. Lewiston, NY: The Edwin Mellin Press, 2009, p. 85

¹³ БНМАУ-ын Гадаад харилцааны баримт бичгүүдийн эмхтгэл. (1921-1961) I Боть, УБ., 1964, 6 дахь тал

¹⁴ Уламбаяр Д. Монгол Улс, Алс Дорно дахин: Олон

улсын харилцаа, геополитик, дипломат ажиллагаа. Тэргүүн боть, УБ., 2013, 238-241 дэх тал

¹⁵ Мөн тэнд

¹⁶ «Эдийн засгийн үндсэн бодлого». Нийслэл Хүрээ. Европын 1921.7.23. ҮТТА. Лавлах номын сан, 3/2330-ын 7-9 дэх тал, хуулга

¹⁷ Лхамсүрэн Б. Монголын гадаад орчин, төрийн тусгаар тогтнол. УБ., 1995, 44 дэх тал

¹⁸ «Эдийн засгийн үндсэн бодлого». Нийслэл Хүрээ. Европын 1921.7.23. ҮТТА. Лавлах номын сан, 3/2330-ын 7-9 дэх тал, хуулга

¹⁹ ҮТТА. Ф.172.Т.5.ХН.92

²⁰ ГХТА. Ф.62.ХН.62. «Монгол ба Тагна-Тыва хоёрын хооронд Найрамдлын Холбоо байгуулах тухай Гэрээ бичиг. Улаанбаатар. 1926.8.26»

²¹ Уламбаяр Д. Монгол Улс, Алс Дорно дахин: Олон улсын харилцаа, геополитик, дипломат ажиллагаа. Тэргүүн боть, УБ., 2013, 360-365 дахь тал

²² Мөн тэнд 356 дахь тал

²³ Addleton Jonathan S. A Most Helpful Factor: US-Mongolia Diplomatic Relations, 1987-2012. Weatherford Foundation, Ulaanbaatar.: 2012, p. 161

Key Issues of Mongolia's «Third Neighbour» Policy: Concept, History and Contemporary Case

Keywords: «third neighbour», «third neighbour» policy, strategic partnership, comprehensive partnership, expanded partnership, equal partnership, multilateral partnership, balance of power

Abstract: This article talks about Mongolia's «third neighbor» policy such is origins of «third neighbour» term, purpose and nature of «third neighbor» policy, implementation mechanism, key issues in contemporary, challenges and idea in Mongolian diplomatic history of XX century.